

## Шашны социологийн онолын орчин үеийн хандлагууд

Цэвээний Цэцэнбилэг, доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс, [tsetsenbilegts@gmail.com](mailto:tsetsenbilegts@gmail.com),

<https://orcid.org/0000-0001-5987-9310>

### Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

### Түлхүүр үгс

шашны социологи,  
секулярчлал,  
постсекулярчлал,  
сонгодог онол, орчин  
үеийн онол, амьд  
шашин

**Хураангуй:** Энэхүү өгүүлэл нь шашны социологийн орчин үеийн онолын хандлагуудыг сонгодог болон орчин үеийн социологийн парадигмуудын харьцуулсан шинжилгээнд тулгуурлан судалсан болно. Эмиль Дюркгейм, Макс Вебер, Карл Маркс нарын шашныг нийгмийн институц, утга учир, эдийн засаг–нийгмийн харилцаатай холбон тайлбарласан сонгодог онолуудын үзэл санааг үндэс болгон авч, Юрген Хабермас, Хосе Казанова, Чарльз Тэйлор, Колин Кэмпбелл, Нэнси Аммерман нарын орчин үеийн онолчдын постсекуляр нийгэм, олон нийтийн шашин, ёс суртахууны орон зай, хувь хүнчлэл, “амьд шашин” зэрэг үзэл баримтлалуудыг задлан шинжилсэн. Судалгаанд чанарын харьцуулсан, тайлбарлах арга зүйг ашиглаж, сонгодог эх сурвалжууд болон орчин үеийн онолын бүтээлүүдэд суурилсан синтез хийв. Шинжилгээний үр дүнд шашны социологи нь нэг шугаман секулярчлалын загвараас татгалзаж, шашныг институцийн доройтол бус, харин соёл, ёс суртахуун, олон нийтийн харилцаанд идэвхтэй оролцогч динамик хүчин зүйл гэж ойлгох чиг хандлага давамгайлж байгааг харууллаа. Дүгнэж хэлбэл, орчин үеийн онолын хандлагууд нь глобалчлал, орчин үеийн, соёлын олон янз байдлын нөхцөлд шашны өөрчлөлтийг илүү нарийвчлалтай тайлбарлах боломж олгож, постсоциалист болон өрнөд бус нийгмүүдэд чиглэсэн цаашдын эмпирик судалгаанд онолын чухал суурь болж байна.

## Modern approaches in sociological theories of religion

Tseveen Tsetsenbileg, Ph.D

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, [tsetsenbilegts@gmail.com](mailto:tsetsenbilegts@gmail.com),

<https://orcid.org/0000-0001-5987-9310>

### Keywords

sociology of religion,  
secularization, post-  
secularism, classical  
theory, contemporary  
theory, lived religion  
© The Author(s), 2025

**Abstract:** This article examines contemporary theoretical approaches in the sociology of religion through a comparative analysis of classical and modern sociological paradigms. Drawing on the foundational contributions of Émile Durkheim, Max Weber, and Karl Marx, the study explores how their structural, interpretive, and materialist frameworks have shaped early understandings of religion as a social institution. The article then analyzes key contemporary theories proposed by Jürgen Habermas, José Casanova, Charles Taylor, Colin Campbell, Nancy Ammerman, focusing on concepts such as post-secular society, public



religion, moral frameworks, individualization, and lived religion. Methodologically, the study employs a qualitative comparative and interpretive approach, synthesizing classical texts and contemporary theoretical literature. The analysis demonstrates that contemporary sociology of religion moves beyond linear secularization models toward pluralistic, context-sensitive interpretations of religious transformation. Religion is no longer conceptualized merely as a declining institution but as a dynamic cultural, moral, and discursive force actively shaping public life, identity, and social meaning. The findings suggest that modern theoretical approaches enable a more nuanced understanding of religion under conditions of globalization, late modernity, and cultural diversity. The article concludes that contemporary sociology of religion represents a paradigmatic shift toward multidimensional, reflexive, and practice-oriented frameworks, offering significant implications for future empirical research, particularly in post-socialist and non-Western contexts.

## I. ОРШИЛ

Орчин үеийн нийгмийн өөрчлөлт, даяаршлын хурдац, технологийн дэвшил, улс төр-соёлын олон төвт байдал нь шашны нийгмийн байр суурь, институцийн хэлбэр, хувь хүний итгэл үнэмшлийн хувирлын тэс ондоо нөхцөлд тулгарч байна. XX зууны турш давамгайлсан секулярчлалын онолын төсөөллөөс ялгаатайгаар XXI зуунд шашин нийгмийн амьдралд нэн идэвхтэй эргэн оролцож буй нь олон улсын социологийн судалгаанд төв асуудал болон гарч ирж байна (Casanova, 1994; Taylor, 2007; Habermas, 2008). Постсекулярчлал, олон шашинт байдлын зохицуулалт, шашны хувийн ба нийтийн орон зай, бодит итгэл үнэмшлийн практик (lived religion), туршлага төвтэй судалгаа (experience-centered research) зэрэг ойлголтууд нь судалгааны шинэ чиг хандлагын тулгуур ойлголтууд болон төлөвшиж байна. Тиймээс тус өгүүлэлд шашны социологийн орчин үеийн онолын хандлагуудыг шашин-төр-нийгмийн харилцааны өөрчлөлтийг онолын түвшинд дахин шинээр томъёолохыг зорив.

XXI зуунд дараах тулгамдсан нийгмийн өөрчлөлтүүд судалгааны гол цөмийг дараах байдлаар бүрдүүлж хэмээн үзэж болно:

- Глобалчлал – соёлын хил хязгаар бүдгэрч, шашин нь шинэ орон зайд дахин тархах, сүлжээний нийгэмд оролцох шинэ хэлбэрүүд (Appadurai, 1996; Beyer, 2013).
- Секулярчлалын шүүмжлэл – шашин буурах бус хэлбэрээ өөрчилж шинэчлэгдэж буйг нотлох олон улсын судалгаа (Berger, 1999; Stark & Finke, 2000).
- Постсекулярчлал – шинжлэх ухаан, либерал ардчилал давамгайлсан хэмээн үзэгдэж байсан олон нийтийн орон зайд шашны дуу хоолой дахин ил тод болж буй процесс (Habermas, 2008).
- Шашны практикийн хувьсал – хувь хүний түвшинд “холимог итгэл үнэмшил”, “сонгон ашиглах шашин”, “шашинлаг бус сүнслэг” (spiritual but not religious), шинэ эко-шашны чиглэлүүд.
- Дижитал орчин дахь шашин – цахим сүлжээ, социал платформ, виртуал нийгэмшлийн орчин нь шашны шинэлэг хэлбэрүүдийг бий болгох.

Эдгээр нийгэм-соёлын томоохон өөрчлөлтүүд нь шашны тухай уламжлалт онолын ойлголтуудын боломжит хязгаар, мөн тэдгээрийг дахин

тайлбарлах шаардлагыг бий болгож байгаа юм.

Судалгааны зорилго — өнөөгийн шашны социологийн онолын орчин үеийн хандлагуудыг (постсекулярчлал, олонлог шашинт байдал, шинэ институцлал, дижитал шашин, амьд шашны судалгаа гэх мэт) тогтолцоот байдлаар нэгтгэн шинжилж, сонгодог онолын өвтэй холбон тайлбарлах.

Судалгааны ач холбогдол нь:

1. Шашны нийгмийн үүрэг болон оролцооны шинэ хэв маягийг онолын түвшинд тодорхойлох;
2. Сонгодог уламжлал болох Дюркгейм, Вебер, Маркс нарын сэтгэгчдийн үзлийг орчин үеийн онолуудын залгамж холбоог шинжлэх;
3. Шашныг зөвхөн уламжлалт институц бус, өргөн хүрээний соёл-сэтгэлгээний үзэгдэл хэмээн шинэ өнцгөөс харахад оршино.

## **II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

Энэхүү судалгаа нь чанарын шинжтэй, онолын судалгааны загварыг ашигласан бөгөөд шашны социологийн орчин үеийн чиг хандлагуудыг системтэйгээр нэгтгэн шинжилж, сонгодог онолын суурьтай холбох

## **III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

### **Сонгодог онолын үндэс**

Сонгодог социологийн гурван багана болох Дюркгейм, Вебер, Маркс нар шашныг нийгмийн бүтцэд эзлэх байр суурь, ямар үүрэгтэй болохыг тайлбарлах анхны системтэй онолын загваруудыг боловсруулсан болой. Эдгээр онол нь орчин үеийн судалгааны онолын шинэ хандлагыг ойлгох суурь болно. Эдгээрийг товч байдлаар авч үзье.

Эмиль Дюркгейм шашныг юун түрүүнд нийгмийн эв нэгдлийн механизм гэж үзсэн бөгөөд “зохиомол бус, харин нийгмийн бодит байдал” хэмээн тодорхойлсон (Durkheim, 1912). Түүний ойлголтоор шашин нь:

зорилготой. Онолын шинжилгээнд харьцуулсан онолын арга болон сэдвийн шинжилгээний аргуудыг түлхүү ашиглав. Ингэхдээ бидний судалгааны сэдэвт хамаарах онолуудыг сонгон авч, тэдгээрийн хоорондын уялдаа, ялгаа, логик холбоог тодорхойлж, шинэ аналитик бүтцийг бий болгоход чиглэдэг системчилсэн онолын шинжилгээний аргыг хэрэглэв. Энэхүү судалгаа нь туршилт, тоон мэдээлэл дээр үндэслэхгүй учир үзэл санааны шинжилгээ, концепцын ангилал, онолын харьцуулалт, текст–дискурс дүн шинжилгээ зэрэг арга зүйг түлхүү ашиглав.

Судалгааны хязгаарлалт: а. Судалгаа нь суурь онолын шинжилгээнд төвлөрч, өөрийн эмпирик өгөгдөлд тулгуурлаагүй; б. Монголын кейсийг тусгайлан судлаагүй, харин барууны онолын суурь ба боломжит хэрэглээг танилцуулах хүрээнд хязгаарлагдсан; в. Өргөн хүрээний онолын материал багтах тул бүх чиглэлийг гүнзгий хамрах боломжгүй аж.

Судалгааны ёс зүй: Онолын судалгаа нь хүний өгөгдөл шаарддаггүй тул эрсдэл багатай.

- Нийгэм дэх “ариун” ба “шашны бус” (sacred/ profane) хоёрыг ялгаж, хамтын ухамсрын бүтцийг бий болгодог;
- Ёслол, зан үйлийн практикаар дамжуулан хүмүүсийг нэгтгэх хамтын оргилот (экстаз, collective effervescence) бий болгодог;
- Шашны институци нь нийгмийн сахилга дэг журмыг тогтоох суурь тогтолцоо юм.

Дюркгеймын тодорхойлсноор шашны утга нь бэлгэ тэмдэг ба зан үйлийн системд бус, харин нийгмийн уялдаа холбоог бий болгох үүрэгт орших аж.

Харин Вебер шашныг чиг үүрэг бүхий байгууламж бус, утгын бүтцэд

суурилсан соёлын хүч хэмээн харсан. Макс Вебер шашныг ойлгохуйн социологи буюу хүний үйлдлийн утга учрыг ойлгох судалгааны талаас тайлбарласан (Weber, 1922/1978). Түүний гол үзэл санаа:

- Шашны этик (жишээлбэл Протестант ёс суртахуун) нь нийгмийн өөрчлөлтийн ухамсарт хөдөлгөгч хүч болж капитализмын хөгжилд нөлөөлсөн;
- Рационалчлалын процесс нь шашныг ид шидээс салгаж системчилдэг боловч шашин нь өөрөө рационал сэтгэлгээний хөгжилд хувь нэмэртэй;
- Харизматик удирдагч, шашны практик, шашны өөрчлөлтийн хэлбэрүүдийн социологийн ангиллыг боловсруулсан билээ.

Карл Маркс шашныг нийгэм-эдийн засгийн харилцааны тусгал гэж үзсэн бөгөөд алдарт “шашин бол олныг мансууруулагч хар тамхи” хэмээх санааг дэвшүүлсэн нь алдартай үгс болж хожим социалист орнуудад шашныг устгах уриа болж хувирсан. Гэвч Марксын гол санаа нь илүү нарийн:

- Шашин нь гаднын дарлал, эдийн засгийн тэгш бус байдлын эсрэг сэтгэл зүйн дэмжлэг болой;
- Үзэл суртлын тогтолцооны нэг хэсэг болж нийгмийн ангийн харилцааг хууль ёсны мэт болгодог;
- Материаллаг амьдралын нөхцөл өөрчлөгдвөл шашин өөрөө өөрчлөгдөх буюу үгүй болох боломжтой.

Марксын тайлбар нь шашныг нийгмийн бүтэцтэй холбон шинжлэх материалист суурийг тавьсан.

Ийнхүү шашны социологийн XIX, XX зууны эхэн үеийн сонгодог тайлбарууд нь шашныг нийгмийн бүтэц, рационалчлал, улс төр, эдийн засгийн суурь хүчин зүйлтэй холбон тайлбарлах онолын хүрээ бүрдүүлсэн байдаг. Дюркгейм (1912) шашныг хамтын ухамсрын илрэл, Вебер (1922) шашны утгын бүтэц ба рационалчлалын эхлэл,

Маркс (1844/1975) ангийн бүтэц ба эдийн засгийн харилцааны илрэл гэж харсан нь шашны нийгмийн байр суурийг том макро түвшинд тодорхойлсон билээ.

XXI зууны орчин нөхцөл (глобалчлал, дижиталчлал, соёлын олон талт байдал, постсекуляр нийгмийн эргэлт гм.) энэ сонгодог загварын зарим сэдвийг өргөжүүлэн, заримыг нь шүүмжлэн, шинэ онолын хандлагуудыг бий болгов (Habermas, 2006; Casanova, 1994; Taylor, 2007; Ammerman, 2020; Campbell, 2013 etc).

Цааших хэсэгт сонгодог онол ба орчин үеийн чиг хандлагыг дараах гол сэдвээр харьцуулан шинжилнэ:

1. Шашны нийгмийн үүргийн тухай ойлголт
2. Шашин ба утга, сэтгэлгээ
3. Шашин ба нийгмийн өөрчлөлт
4. Институт, эрх мэдэл, олон нийтийн оролцоо
5. Дижитал шашин

1. Шашны нийгмийн үүрэг  
Дюркгеймийн хувьд шашин бол нийгмийн эв нэгдлийн гол бүтэц, “хамтын ухамсар”-ын илэрхийлэл бөгөөд ёс суртахууны нэгдмэл байдлыг хадгалах үүрэгтэй, нийгмийг тогтвортой байлгах механизм юм (Durkheim, 1912/1995). Орчин үеийн судлаачид шашныг нэг нэгдмэл бүтэц бус, олонлог амьд практик (“lived religion”) хэлбэрээр оршихыг онцолдог (Ammerman, 2020; Orsi, 1997). Аммерман, Орси нар шашныг өдөр тутмын дадал суусан, хувь хүний туршлагаар зохиогддог, институцийн бус, гэр бүл, соёл, онлайн орчин, хөдөлгөөнүүдээр дамжин хэлбэрших болсныг судалсан аж. Дюркгейм шашныг нийгмийн нэгдлийн механизм хэмээсэн бол орчин үеийн чиглэлүүд шашныг олон төвт, амьд туршлагын сүлжээ гэж хардаг.

2. Шашин ба утга, сэтгэлгээ  
Веберийн үзнээр шашин бол тодорхой соёлын утга бүтээх механизм ба

нийгмийн рационалчлалын эхлэл хийгээд тэрээр амьдралын утга, авралын гарц, ёс суртахууны логикийг тодорхойлдог (Weber, 1922/1978). Касанова, Асад, Тэйлор зэрэг орчин үеийн судлаачид шашинд нэг “том утга” биш харин олон төв, олон субъектын холимог гэж дүгнэсэн байдаг. Тухайлбал Чарльз Тэйлорын “Шашингүйжих үе” хэмээх 2007 онд хэвлэгдсэн бүтээлдээ нь секуляризацийн онолын хувьд түгээмэл "Яагаад сүм хийдүүд хоосорч байна вэ?" гэсэн асуултыг илүү гүнзгийрүүлж тавьсан: "1500 онд бүх нийтээр бурханд итгэдэг байсан нийгэм хэрхэн 2000 онд итгэх олон сонголттой болсон бэ?" Тэйлорын хувьд шашингүйжих гэдэг нь шашин алга болох биш, харин итгэл үнэмшлийн орчинтой холбож шашны өөрчлөлтийг нийгмийн сэтгэлгээ буюу "итгэх арга зам"-ын өөрчлөлтөөр тайлбарласан.

Колин Кэмпбеллийн онолын гол цөм нь шашин нь орчин үеийн нийгэмд зөвхөн уналтад орох бус, харин хэлбэрээ өөрчилж, хувь хүний түвшинд шинэ утга учиртай болж байгааг алдартай бүтээлдээ шашин нь хэрхэн орчин үеийн хэрэглээний соёлыг (consumerism) бий болгосныг тайлбарладаг (Campbell C., 1987). Макс Вебер протестант ёс зүй нь капитализмыг төрүүлсэн гэж үзсэн бол, Кэмпбелл "Романтик ёс зүй" нь орчин үеийн хэрэглээг (Modern Consumerism) бий болгосон гэж үздэг. Тэрээр романтизм нь сэтгэл хөдлөл, дотоод мэдрэмж, мөрөөдөл зэргийг дээдэлдэг нь орчин үеийн хүмүүсийг тогтмол шинэ туршлага, таашаалыг эрж хайх зан төлөвт оруулсан. Хэрэглээ нь энэхүү сэтгэл хөдлөлийн хэрэгцээг хангадаг хэрэгсэл болдог. Хүн худалдан авалт хийснээр, эсвэл шинэ туршлагад оролцсоноор өөрийгөө илэрхийлж, дотоод хоосон орон зайг нөхөхийг хичээдэг. Сүнслэг эрэл хайгуулын соёл хэсэг нь нь шашны социологид шууд хамааралтай бөгөөд орчин үеийн

шашныг тайлбарлахад гол суурь болдог. Орчин үеийн хүмүүс тогтсон шашны харьяаллыг дагах бус, харин өөрсдөө сүнслэг болон гүн ухааны асуултуудад хариулт олохыг эрмэлздэг. Энэ бол "Сүнслэг Эрэл Хайгуул" юм. Энэ хандлага нь уламжлалт сүм хийдээс гадуурх шинэ сүнслэг хөдөлгөөнүүд, Шинэ үе (New Age) практик, йог, бясалгалын курсууд болон өөрийгөө хөгжүүлэх (self-help) соёл хүчтэй дэлгэрэх үндэс болсон. Хүмүүс янз бүрийн шашин, соёлын зан үйл болон итгэл үнэмшлийн элементүүдийг хольж (Syncretism), өөртөө тохирсон "сүнслэг багц"-ыг бий болгодог. Энэ нь шашныг бүлгийн харьяалал гэхээсээ илүү хувь хүний амьдралын хэв маяг болгон хувиргаж байна. Түүний үзэж буйгаар, орчин үеийн хүмүүс рациональ болсноор шашнаас хөндийрөх бус, харин сэтгэл хөдлөлөө (emotion) удирдах, утга учрыг бий болгох шинэ, хувь хүнчлэгдсэн аргуудыг шаардаж байна. Шашин нь энэхүү хэрэгцээг хангах үйлдэл хэвээр байгаа юм.

Колин Кэмпбелл шашны социологийн онолд Макс Веберийн ёс зүйг романтик соёл болон хэрэглээний нийгэмтэй холбосноор шашныг хувь хүнчлэх үйл явцыг тайлбарласан чухал онолыг бий болгосон.

Ийнхүү Веберийн рационал логикт төвлөрсөн бүтэц орчин үед соёлын болон туршлагын олон хэлбэрт суурилсан утгад шилжив.

3. Шашин ба нийгмийн өөрчлөлт  
Марксын үзнээр шашин бол “хүний зовлонгийн үзэгдлийн нулимс” бөгөөд ангийн дарлалтай холбоотой үзэл суртлын хэрэгсэл, давамгайлсан ангийн ашиг сонирхлын бүтээгдэхүүн, нийгмийн зохицуулалтын механизм гэж үзсэн (Marx, 1844/1975). Петер Байер, Мишель Фуко, Роза Брайдотти зэрэг эрдэмтэд шашныг глобалчлал, дижиталчлал, эрх мэдлийн шинэ

хэлбэрүүдийн үүднээс хэрхэн судлахыг тайлбарладаг.

Петер Байер шашны өөрчлөлтийг глобалчлалын контексттэй нягт холбож үзсэн. Ингэхдээ глобалчлал нь шашныг үндэсний улсын (nation-state) хүрээнээс гаргаж, нийтлэг глобал системийн нэг хэсэг болгодог. Шашны байгууллагууд үндэстэн дамнасан сүлжээ (transnational networks) үүсгэж, улс төр, эдийн засагт нөлөөлөх чадвартай болсон. Шашин нь нийгмийг нэгтгэх (Дюркгейм) болон ялгах (Вебер) үүргийг гүйцэтгэхээс гадна, глобал систем дотор нэгэн зэрэг олон үүргийг гүйцэтгэж байна. Байер Рациональ Сонголтын Онол (RCT)-ыг глобал түвшинд хэрэглэж, шашны олон ургальч байдал (pluralism) нь шашныг сулруулах бус, харин өрсөлдөөнийг нэмэгдүүлснээр итгэл үнэмшлийн эрч хүчийг хадгалж байна гэж үздэг. Глобалчлал нь шашны зах зээлийг улам тэлж, итгэлтнүүдэд илүү олон сонголт олгож байна. Түүнчлэн Байер онлайн технологи нь шашны бүтэц, харилцааг өөрчилж буйг судалдаг. Дижитал талбар нь шашны байгууллагуудад хил хязгааргүй номлол тараах, виртуал нийгэмлэг үүсгэх, мөн улс төрийн үзэл суртлаа түгээх боломжийг олгож, глобалчлалын үйл явцыг түргэсгэж байна.

Рози Брайдотти орчин үеийн, технологижсон ертөнцөд шашин болон хүний бие хэрхэн өөрчлөгдөж буйг судалдаг. Тэрээр технологи, генетик, хиймэл оюун ухаан зэрэг нь "хүн" гэдэг ойлголтыг өөрчилж буй шинэ орчинд шашин нь ёс суртахууны болон онтологийн (оршихуйн) суурь асуудлуудад хариулт өгөх чадалтай хэвээр байгааг онцлон үүнийг эмэгтэйчүүдийн дарангуйлагч гэж үзэхийн оронд орчин үеийн нийгэм дэх шашныг эмэгтэйчүүдийн эрх чөлөөний эх сурвалж байж болох шинэ феминист хандлагыг дэвшүүлжээ.

Ийнхүү орчин үеийн судлаачдын хувьд шашин бол соёл хоорондын капиталын хөдөлгөөн, улсаас гадуурх хүчин, глобал сүлжээний хэсэг (Beuer, 2013), биополитикийн зохицуулалт (Braidotti, 2013) болсон.

#### 4. Институт, эрх мэдэл, олон нийтийн оролцоо

Юрген Хабермасын дэвшүүлсэн постсекуляризмын онол секуляризацийн онолыг амжилтгүй болсныг хүлээн зөвшөөрч, XXI зуунд шашны болон секуляр (шашингүй) иргэдийн нийтийн орон зайд хэрхэн зөвшилцөж, хамтран оршин тогтнох ёстойг тайлбарладаг орчин үеийн нийгэмд шашин албан ёсны институт бус олон нийтийн диалогийн нэг субъект болсон гэж үздэг (Habermas, 2006, 2008). Шашин иргэний нийгмийн талбарын нэг хэсэг, ёс суртахууны мэдрэмжийн эх үүсвэр, рационал хэлэлцүүлгийн нэг оролцогч хэмээн үүнийг хувь хүний хувийн (private) орон зайд шахагдахаас илүүтэй ёс зүй, ёс суртахуун болон нийгмийн үнэт зүйлийн тухай асуудлаар нийтийн хэлэлцүүлэгт оролцох тэгш эрхтэй дуу хоолой юм. Учир нь секуляр онол нь нийгмийн үнэт зүйл эсвэл ёс суртахууны суурь асуудлуудыг бүрэн тайлбарлаж чадахгүй. Харин шашин нь эдгээр асуудлаар утга учир болон чиглүүлэг өгөх чухал нөөц байж чадна. Хабермасын онол нь шашин нь зөвхөн хуучин үеийн үлдэгдэл биш, харин орчин үеийн нийгмийн нэг хэсэг гэдгийг баталгаажуулдаг.

Хосе Казановагийн гол бүтээл болох "Орчин үеийн дэлхий дэх нийтийн шашин" нь шашны социологийн секуляризацийн онолыг шүүмжилж 1970–1990-ээд онуудад дэлхий даяар (Католик сүм дэх Теологийн чөлөөлөх хөдөлгөөн, Исламын хувьсгал, Польш дахь Католик сүм) шашин нь улс төр, нийтийн амьдралд эргэн орж ирж буйг "Нийтийн шашны" сэргэлтээр тайлбарлав. Тэрээр шашин нь зөвхөн

хувийн асуудал байхаа больж, нийгмийн зөрчил, шударга ёс, үндэсний тусгаар тогтнолын асуудлуудад идэвхтэй оролцох болсныг нотлов.

Францын философич Мишель Фуко шууд шашныг судлаагүй ч, түүний эрх мэдэл, мэдлэг, биеийн тухай онол нь шашны институт болон итгэлтний хувийн амьдралыг хэрхэн тайлбарлах арга зүйг өөрчилсөн. Фукогийн хувьд эрх мэдэл нь төрийн аппарат-т төвлөрсөн, хязгаарлагдмал зүйл биш, харин нийгмийн бүх түвшинд тархсан харилцаа юм. Фукогийн онол шашныг итгэл үнэмшил гэхээсээ илүү практик гэж үздэг. Шашны зан үйл, дэг журам, биеийг хянах аргууд (залбирал, мацаг барих, бэлгийн харилцааны хяналт гм.) нь эрх мэдлийн технологи болж, сүсэгтний бие болон ухамсрыг хэлбэржүүлдэг. Фуко мэдлэг ба эрх мэдэл хоёр салшгүй холбоотой (power/knowledge) гэж үздэг. Шашны номлол болон шашны түүх нь мэдлэгийг үүсгэж, энэ мэдлэг нь тухайн шашны байгууллагын эрх мэдлийг зөвтгөх хэрэгсэл болдог.

Ислам судлаач Талал Асад Фукогийн онолыг ашиглан, ислам дахь зан үйл нь хүмүүсийг тодорхой зан төлөвт сургадаг, улмаар эрх мэдлийн бүтцийг хадгалдаг гэж тайлбарласан. Талал Асад шашныг тодорхойлох арга зам болон эрх мэдлийн асуудлуудад анхаарлаа хандуулдаг. Түүний гол бүтээл "Шашны генеологи" нь постсекуляр хэлэлцүүлгийг гүнзгийрүүлсэн (Asad, 1993). Асад "шашин" хэмээх ойлголт нь бүх нийтийн бус, харин орчин үеийн баруун, христийн (протестант) ертөнцөд үүссэн, түүхэн болон улс төрийн тодорхой нөхцөл байдалд тулгуурласан ойлголт гэж үздэг. Тэрээр шашны практик (ritual) болон хувь хүний биеийн (body) хэрхэн хоорондоо холбогдож буйг Фукогийн эрх мэдлийн онолоор тайлбарладаг. Шашин бол зөвхөн итгэл биш, харин тодорхой дүрэм журам,

дадал зуршлаар дамжуулан хүнийг "хүмүүжүүлэх" буюу нийгмийн гишүүн болгодог эрх мэдлийн бүтэц юм. Шашны үйлдэл нь түүхэн контекст, эрх мэдлийн харилцаанд оршин нийгмийн амьдралаас шахагдаагүй, харин улс төр-иргэний орон зайд эргэн орж ирсэн гэв.

Ийнхүү сонгодог онолд шашин институт төвтэй байсан бол орчин үеийн онолд иргэний нийгмийн олонлог тоглогч болон хувирсан.

## 5. Дижитал шашин

Хайди Кэмпбелл болон Стивен Хатчингс нар нь дижитал шашны (Digital Religion) болон Медиа/Соёл Судлалын хүрээнд шашныг орчин үеийн технологи (сошиал медиа, интернет)-ын нөлөөгөөр хэрхэн өөрчлөгдөж буйг тайлбарладаг. Хайди Кэмпбелл нь дижитал шашны салбарын үндэслэгч бөгөөд түүний гол бүтээлүүд нь шашны нийгэмлэгүүд (religious communities) цахим технологийг хэрхэн ашиглаж, хэрхэн хувьсан өөрчлөгдөж буйг судалдаг. Кэмпбелл дижитал шашныг зөвхөн "интернет дэх шашин" гэж үзэхээс татгалзаж, технологи ба шашны практик хоёрын харилцан нөлөөллийг онцолж шашны бүлгүүд технологийг ашиглахдаа шууд хуулбарлах бус, харин өөрсдийн уламжлал, утга учрыг хадгалахын тулд технологийг дахин хэлбэржүүлж ашигладаг. Жишээ нь: Хэрэв сүм хийд Facebook Live-аар мөргөл хийж байвал, энэ нь зүгээр л камер тавьсан хэрэг биш, харин уламжлалт мөргөлийн утга учрыг виртуал орон зайд хэрхэн шилжүүлж, хамтын мэдрэмжийг хадгалахыг зорьж буй үйл явц юм. Тэрээр шашин ба технологи хоёрыг тусдаа зүйл гэж үзэхээс татгалзаж, шашны нийгэмлэг дотор технологийн хэрэглээ нь шинэ уламжлал болон дүрэм журам, физик болон виртуал орон зайн хязгаарыг хэрхэн тогтоож, нийгмийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлж буйг (жишээлбэл,

онлайнгаар хэнийг хүлээн зөвшөөрөх, хэнийг хасах) судалдаг (Campbell, 2013).

Стивен Хатчингс нь голчлон медиа, хэлэлцүүлэг ба Оросын/Зүүн Европын улс төрийн болон соёлын контекст дэх шашныг Фукогийн эрх мэдлийн онолыг медиа болон шашинтай холбон судалдаг. Гол анхаарал нь шашны болон секуляр (шашингүй) бүлгүүд медиа орон зайд (ялангуяа мэдээллийн хэрэгсэл, нийтийн хэлэлцүүлэгт) эрх мэдэл болон үнэнийг хэрхэн тогтоож буйг шинжлэх явдал юм. Хатчингс медиаг шашны байгууллагууд болон төр үндэсний үнэт зүйл, ёс суртахуун, уламжлалын тухай ямар хэлэлцүүлгийг ноёлох зорилгоор ашиглаж буйд анхаарлаа хандуулдаг. Тухайлбал, Орос болон Зүүн Европын посткоммунист орнуудад уламжлалт шашин нь үндэсний онцлог, төрийн үзэл суртлыг бэлгэдэн улс төрийн хэлэлцүүлэгт хэрхэн оролцож, ардчилал болон либерализмын эсрэг ямар байр суурь эзэлж буйг онцолсон (Hutchings, 2017). Ийнхүү сонгодог онол нь шашны үндсэн логик, нийгмийн үүрэг, утгын эхлэлийг тайлбарлах суурь хэвээр үлдэж буй ч орчин үеийн онолын хүрээнд шашин олон хэлбэртэй, даяршлагдсан, цахимжсан, институцийн бус, бодит туршлагын төвтэй болсныг харуулж байна.

#### **IV. ХЭЛЦЭМЖ**

Сонгодог онолууд шашныг нийгмийн институцийн тогтолцооны нэг хэсэг, эсвэл нийгмийн бүтэц, эрх мэдлийн илэрхийлэл гэж үзэж ирсэн. Орчин үеийн барууны эрдэмтдийн шашны социологид онолын гол дараах хандлагыг нэрлэж болно.

Постсекуляр онол

Юрген Хабермас болон Хосе Казановагийн бүтээлүүд нь шашны социологид томоохон онолын эргэлт хийсэн. Тэд шашныг орчин үеийн нийгэмд “устаж буй үзэгдэл” бус, харин өөр хэлбэрээр дахин оролцогч хүчин гэж

үздэг. Хабермасын постсекуляр ойлголт нь шашны мэдлэг, ёс суртахууны нотолгоо олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох боломжтойг хүлээн зөвшөөрч секуляр “дан ноёрхол”-ыг шүүмжилсэн аж. Касанова шашныг хувь хүнд хамаатай үзэгдэл бус, харин улс төр, иргэний нийгэмд идэвхтэй оролцогч гэж үздэг. Эдгээр онолууд нь сонгодог секулярчлалын парадигмыг бүрэн үгүйсгэхгүй ч хэдий нөхцөлт, түүхэн, бүс нутгийн онцлогтой гэж дахин тайлбарлав.

Соёл, субъектив байдал ба “амьд шашин”

Чарльз Тейлор, Колин Кэмпбелл, Нэнси Аммерман нар шашныг институцээс гадуур, өдөр тутмын амьдралын түвшинд судлах шаардлагыг онцолдог. Тэйлор шашныг “ёс суртахууны орон зай” гэж тайлбарлаж, орчин үеийн хүний ёс суртахууны эрэл хайгуултай холбоход Кэмпбелл орчин үеийн шашинлаг байдлыг хувь хүний соёлын төсөөлөл, романтик ёс суртахуунтай уялдуулж Аммерман “lived religion” хандлагаар дамжуулан шашныг практик, туршлага, өдөр тутмын үйлдлээр судлахыг санал болгов.

Эдгээр хандлагууд нь шашныг нийгмийн бүтэц бус, харин утга бүтээх амьд үйл явц гэж харах боломж олгож байна. Дээрх онолуудыг нэгтгэн үзвэл орчин үеийн шашны социологид:

1. Нэг шугаман секулярчлалын онолоос татгалзах
2. Олон төвт, олон хэлбэрт шашинлаг байдлыг хүлээн зөвшөөрөх
3. Институцээс практик, субъектив туршлагад шилжих
4. Шашин-улс төр-олон нийтийн орон зайн харилцааг дахин үнэлэх зэрэг үндсэн шинжүүд ажиглагдаж байна

Энэ нь шашныг орчин үеийн нийгмийн захын үзэгдэл бус, харин соёл, ёс суртахуун, иргэний оролцооны чухал

хүчин зүйл гэж ойлгох онолын суурийг бүрдүүлж байна.

XX зууны гол сонгодог социологийн тайлбарууд (Дюркгейм, Вебер, Маркс) шашны нийгмийн байр суурийг тогтолцооны түвшинд тайлбарласан бол XXI зуунд шашин туршлагын, материаллаг, сүлжээний, дижитал, улс хоорондын хэлбэрт илүүтэй судлагдах болжээ (Ammerman, 2020; Campbell, 2013; Vásquez, 2011). Энэ нь онолын талбар дахь эпистемологийн өргөжилт болон арга зүйн олонлогийн илрэл юм. Сонгодог онолууд орчин үеийн нийгмийн нөхцөлд үнэ цэнээ алдсан бус, харин шинэ нөхцөлд дахин уншигдаж, орчин үеийн үзэгдлүүдийг ойлгоход суурь хэвээр байна. Тухайлбал Гордон Линч “Шинэ сүнслэг байдал” бүтээлд "Шашин ба Сүнслэг байдал" (Religion and Spirituality) гэсэн хоёр ойлголтын хоорондох ялгааг тодорхойлж, орчин үеийн нийгэмд яагаад сүнслэг байдал (spirituality) нь шашин (religion)-аас илүү хүчтэй нөлөөтэй болж буйг тайлбарладаг (Lynch, 2021). Линч шинэ сүнслэг үзлүүд нь уламжлалт шашнаас татгалзсан хоосон орон зайг нөхөхөөс илүүтэй, орчин үеийн соёлын шаардлагаар бий болсон гэж үздэг. Хүний амьдрал улам бүр бодгальчилж, бие даасан байдал чухалчлагдах тусам, сүнслэг байдал нь бусдын хяналтаас ангид, өөрийнхөө мэдрэмж, хэрэгцээнд тулгуурлан утга учрыг бий болгох арга зам болдог. Шинэ сүнслэг үзлүүд нь ихэвчлэн "шинэ үе" (New Age) болон сайн сайхан амьдрах (Wellness) соёлтой холбогдож, зах зээлийн бүтээгдэхүүн (номын худалдаа, курс, йогийн студи, онлайн зөвлөгөө) хэлбэрээр худалдаалагддаг. Энэ нь Рациональ Сонголтын Онол (RCT)-ын шашныг зах зээл гэж үзэх үзэлтэй нийцдэг. Линч орчин үеийг "секуляр" гэхээсээ илүү "Сүнслэг үе" гэж нэрлэх нь зөв гэж үздэг. Энэ нь хүмүүс Бурханд итгэхээ больсон

хэрэг биш, харин Бурхантай харилцах болон утга учир хайх арга нь шинэ, олон янзын хэлбэрт шилжсэн гэсэн үг юм. Тэрээр хувь хүмүүс өөрсдийн сүнслэг "багц"-ыг бий болгохын тулд Буддизм, Бөө, Христийн шашны элементүүд болон орчин үеийн сэтгэл судлалын аргуудыг чөлөөтэй хольж хэрэглэдэг явдал түгээмэл болсныг онцолжээ. Линчийн шинжилгээг фан клуб онлайн мөргөл, шууд дамжуулах зан үйл мэт үзэгдлүүдийг Дюркгеймийн “хамтын оргилолт” (collective effervescence) ойлголт, зан үйлийн шинжилгээтэй холбож болох юм (Durkheim, 1912; Lynch, 2021).

Веберын эрх мэдлийн харизма талаарх үзэл онлайн манлайлагч нарын (онлайн пасторууд, TikTok-ийн сүнслэг нөлөөлөгчид) судалгаанд одоо ч ач холбогдолтой байна.

Марксын үзэл суртлын шүүмжлэл, алгоритмын эрх мэдэл, платформ капитализм, мэдээллийн тэгш бус байдал дотор дахин шинээр утга авч байна (Zuboff, 2019).

*Орчин үеийн онолын зөрчил ба хязгаарлалт*

Өнөөгийн онолууд шинэлэг хэдий ч гурван үндсэн хязгаарлалттай. Үүнд:

- Эмпирик судалгаа хангалтгүй. Lived religion, digital religion гэх мэт чиглэлүүд эмпирик кейс цөөн, баримтад тулгуурлах нь нэг шугамтай байх хандлагатай.
- Хэт хийсвэрлэгдсэн. Пост-хүний философи, материаллаг эргэлт (Braidotti, 2013; Haraway, 1991) нь өргөн хүрээний, ойлгоход төвөгтэй.
- Барууны төвтэй онолын давамгайлал. Asad (1993), Mahmood (2005) зэрэг судлаачид шашны онол барууны либерал уламжлалаас ангид биш, харин түүний бүтээгдэхүүн гэдгийг шүүмжилдэг.

Сонгодог шашин-социологийн онолууд нь өнөөдөр ч ач холбогдлоо хадгалсаар байгаа ч дэлхийн, дижитал, постсекуляр

өөрчлөлтүүдийг бүрэн тайлбарлахад хүрэлцэхгүй. Орчин үеийн онолын хандлагууд туршлага, материаллаг байдал, сүлжээ, технологи, олон төвт утга гэсэн шинэ сэдвүүдийг авчирсан нь энэ талбарыг мэдлэгийн олонлог болгожээ.

Дээрх онолын хандлагуудыг Монголын шашны судалгааны онолын суурь болно гэж үзэж байна. Үүнд:

1. Постсоциалист шашны эргэлт — социализмын дараах шашны дахин сэргэн мандалтын загвар
2. Ерөнхий болон холимог сүсэг бишрэлийн онол — буддизм, бөө

## V. ТАЛАРХАЛ

Талархал. Энэхүү өгүүллийг Монгол Улсын ЭЗХ-ийн яам, Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны сантай хамтарсан “Орос, Монгол дахь уламжлалт буддизм, шашны дараах болон орчин үеийн нийгэм-улс төрийн үйл явц” (2024-2026) төслийн хүрээнд бичиж боловсруулсан болно

## VI. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь шашны социологийн сонгодог гурван суурь онол болон XXI зууны олон талт, хэсэгчилсэн, туршлага–сүлжээ төвтэй орчин үеийн чиг хандлагуудын хоорондын харилцан уялдаа, ялгаа, давтамж, зөрчлийг гүнзгий шинжилж үзэв. Судалгааны үр дүнгээс харахад шашны нийгмийн байр суурийг тайлбарлах онолын парадигм нэг шулуун замаар “ахицтайгаар” хөгжсөн бус, харин олон төвт, олон урсгалт мэдлэгийн орон зай болон өргөжжээ.

Бидний авч үзсэн сонгодог онолын гурван гол чиглэл—Дюркгеймийн нийгмийн интеграцийн цөм үзэл, Веберийн рационалчлал ба утга бүтээлийн анализ, Марксын эдийн засаг–ангийн харилцаанд суурилсан шүүмжлэл—нь шашныг тогтолцооны түвшинтэй холбон тайлбарласан хэвээр байна. Гэвч орчин үеийн нийгмийн өөрчлөлтүүд, тухайлбал глобалчлал,

мөргөл, шинжлэх ухаан зэрэг холимог практик

3. Монголын дижитал-буддизмын загвар — онлайн сүсэг бишрэл ба институцийн өөрчлөлтийн харилцаа
4. Эрх мэдлийн шинэ эргэлт — уламжлалт ламын эрх мэдэл буюу социал медиагийн лидерүүд.

Монголын нөхцөл нь эдгээр онолыг практик дээр турших, цаашид хөгжүүлэх бүрэн боломжтой.

дигитал медиатизаци, постсекуляр олон нийтийн орон зайн тэлэлт, амьд практик–туршлагын социологи, транснациональ урсгал, материаллаг эргэлт зэрэг нь шашныг зөвхөн институцийн, эдийн засгийн, рационал хийсвэр бүтцээр тайлбарлах боломжийг хязгаарлаж байна. Орчин үеийн онолын чиглэлүүд (Хабермас, Тэйлор, Казанова, Кэмпбелл, Аммерман, Васкес, Брайдотти, Асад зэрэг) нь шашныг олон утгат, өдөр тутмын практикт шингэсэн, дижитал медиад дахин бүтэцлэгдсэн, физик ба виртуал орон зайн сүлжээнд дамжин өргөгжсөн, улс хоорондын урсгалаар дахин зохион байгуулагдсан, биополитикийн зохицуулалтын нэг хэсэг болсон динамик, төлөвшиж буй үзэгдэл гэж тодорхойлж байна. Энэ нь шашны судалгааны онолын төв нь тогтолцооны макро түвшнээс туршлага, материаллаг байдал, дижитал медиасын орчин руу шилжиж буйг илтгэнэ. Судалгааны хэлэлцүүлгийн нэг чухал хэсэг нь сонгодог онолын ач холбогдлыг үгүйсгэсэнгүй; харин ч тэдгээр нь орчин үеийн үзэгдлүүдийг тайлбарлах эпистемологийн суурь, мөн нарийн төвөгтэй үзэгдлүүдийг ойлгоход шаардлагатай анхан шатны категори хэвээр байна. Гэвч орчин үеийн шашны судалгааны талбар нь зөвхөн сонгодог

парадигмд тулгуурлах боломжгүй бөгөөд улам бүр салбар хоорондын, орон зай–сүлжээний, туршлага–материаллаг хэлбэрт шилжжээ. Монголын нийгэм, ялангуяа постсоциалист шилжилтийн орчинд шашин дахин сэргэн мандах үзэгдэл нь эдгээр орчин үеийн онолын хэрэглээний чухал кейс болж байна. Монголын буддизмын шинэ институцлал, бөө мөргөлийн дахин идэвхжилт, холимог сүсэг бишрэлийн соёл, онлайн мөргөл ба цахим шашны нийгэмлэгүүд, мөнх тэнгэр, лус–онгодод хандсан амьд практикууд зэрэг нь орчин үеийн шашны онолын парадигмуудыг эмпирик хэмжээнд сорьж, шинэчлэх

боломжтой онцгой туршилтын талбар юм.

Энэхүү судалгааны гол дүгнэлт нь шашныг ойлгох орчин үеийн онолын эрэл нь тухайн үзэгдлийг зөвхөн институц, догматик сургаал эсвэл нийгэм–эдийн засгийн нөхцөлөөр тайлбарлах боломжгүй бөгөөд үүний оронд олонлог амьдралын туршлага, соёлын давхар утга, дижитал болон глобал сүлжээний харилцан нөлөө, биет–материаллаг ба тэнгэрийн бэлгэдлийн, сүнслэг үзэл, улс төрийн олон нийтийн оролцоо зэрэг нийлмэл хүчин зүйлсийн огтлолцолд байрлуулан судлах шаардлагатайг харуулж байна.

#### Ашигласан материал

Ammerman, N. T. (2014). Finding religion in everyday life. *Sociology of Religion*, 75(2), 189–207.

<https://doi.org/10.1093/socrel/sru013>

Ammerman, N. T. (2020). *Studying lived religion: Contexts and practices*. Oxford University Press.

<https://doi.org/10.18574/nyu/9781479804283.001.0001>

Appadurai, A. (1996). *Modernity at Large: Cultural Dimensions of Globalization*. Minneapolis, MN: University of Minnesota Press.

Asad, T. (1993). *Genealogies of religion: Discipline and reasons of power in Christianity and Islam*. Johns Hopkins University Press.

Berger, P. L. (1999). *The Desecularization of the World: Resurgent Religion and World Politics*. Eerdmans/Ethics and Public Policy Center.

Beyer, P. (2006). *Religions in global society*. Routledge.

Beyer, P. (2013). Religion and globalization. In L. Woodhead & R. Catto (Eds.), *Religion and change in modern Britain* (pp. 107–120). Routledge.

Braidotti, R. (2013). *The posthuman*. Polity Press.

Campbell C. (1987). *The Romantic Ethic and the Spirit of Modern Consumerism*. Oxford, UK: B. Blackwell.

Campbell, H. (2013). *Digital religion: Understanding religious practice in new media worlds*. Routledge.

<https://doi.org/10.4324/9780203084861>

Casanova, J. (1994). *Public religions in the modern world*. University of Chicago Press.

<https://doi.org/10.7208/chicago/9780226190204.001.0001>

Durkheim, É. (1912/1995). *The elementary forms of religious life* (K. Fields, Trans.). Free Press.

Habermas, J. (2006). Religion in the public sphere. *European Journal of Philosophy*, 14(1), 1–25.

Habermas, J. (2008). *Between naturalism and religion: Philosophical essays*. Malden, MA: Polity Press. <https://doi.org/10.1111/j.1468-0378.2006.00241.x>

Haraway, D. (1991). *Simians, cyborgs, and women: The reinvention of nature*. Routledge.

Hutchings, T. (2017). *Creating church online: Ritual, community and new media*. Routledge.

<https://doi.org/10.4324/9780203111093>

Knott, K. (2015). *The location of religion: A spatial analysis*. Wiley-Blackwell.

<https://doi.org/10.4324/9781315652641>

Levitt, P. (2007). *God needs no passport: Immigrants and the changing American religious landscape*. The New Press.

Lynch, G. (2021). *The new spiritualities*. Routledge.

- Mahmood, S. (2005). *Politics of piety: The Islamic revival and the feminist subject*. Princeton University Press.
- Marx, K. (1844/1975). *Early writings* (R. Livingstone & G. Benton, Trans.). Penguin.
- Orsi, R. (1997). Everyday miracles: The study of lived religion. In D. Hall (Ed.), *Lived religion in America* (pp. 3–21). Princeton University Press.  
<https://doi.org/10.2307/j.ctv143mdcw.4>
- Robertson, R. (1992). *Globalization: Social theory and global culture*. Sage.
- Stark, R., & Finke, R. (2000). *Acts of faith: Explaining the human side of religion*. Berkeley: University of California Press.
- Sutcliffe, S., & Bender, C. (2014). *The Routledge handbook of religion and spirituality in contemporary society*. Routledge.
- Taves, A., & Asprem, E. (2018). *The genealogy of religious experience*. Oxford University Press.
- Taylor, C. (2007). *A secular age*. Harvard University Press.  
<https://doi.org/10.4159/9780674044289>
- Vásquez, M. (2011). *More than belief: A materialist theory of religion*. Oxford University Press.
- Weber, M. (1922/1978). *Economy and society: An outline of interpretive sociology* (G. Roth & C. Wittich, Eds.). University of California Press.
- Zuboff, S. (2019). *The age of surveillance capitalism*. PublicAffairs.